

Үндэсний статистикийн хорооны даргын
2013 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн
1/134 тоот тушаалын 2-р хавсралт

ДНБ-ийг улирлаар тооцох аргачлал

2013 он

ДНБ-ийг улирлаар тооцох аргачлал

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. ДНБ-ийг үйлдвэрлэлийн аргаар, улирлаар, оны үнээр болон зэрэгцүүлэх үнээр тооцох арга зүй

2.1 Ерөнхий зарчим

2.2 Салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоо

- 2.2.1 Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар
- 2.2.2 Уул уурхай, олборлолт
- 2.2.3 Боловсруулах үйлдвэрлэл
- 2.2.4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт
- 2.2.5 Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа
- 2.2.6 Барилга
- 2.2.7 Бөөний болон жижиглэнгийн худалдаа
- 2.2.8 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа
- 2.2.9 Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ
- 2.2.10 Мэдээлэл, холбоо
- 2.2.11 Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа
- 2.2.12 Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
- 2.2.13 Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа
- 2.2.14 Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа
- 2.2.15 Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал
- 2.2.16 Боловсролын үйл ажиллагаа
- 2.2.17 Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа
- 2.2.18 Урлаг, үзвэр, тоглоом наадам
- 2.2.19 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа
- 2.2.20 Бүтээгдэхүүний татвар, татаас

Гурав. ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар, улирлаар, оны үнээр тооцох арга зүй

Дөрөв. ДНБ-ийг эцсийн ашиглалтын аргаар, улирлаар, зэрэгцүүлэх үнээр тооцох арга зүй

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

“ДНБ болон ҮНО тооцох аргачлал”, “ДНБ-ийг улирлаар тооцох аргачлал”-д мөрдөж буй үндсэн зарчим, үзүүлэлтийн нэр, ойлголт, тодорхойлолт, томъёолол, тооцоолох аргачлал нь ижил зарчимтай байна.

Улирлаар тооцогдсон ДНБ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- ДНБ-ийг улирлаар тооцох нь эдийн засгийн хөгжлийн түвшинг харьцангуй богино хугацаанд тодорхойлж, үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй байдлаар харуулж, бизнесийн эргэлт (цикл)-д судалгаа, шинжилгээ хийх, эдийн засгийн бодлогыг богино хугацаанд хэрэгжүүлэх, эконометрик загварчлалд ашиглах суурь мэдээллийг бий болгох, мэдээллийн чанарт хяналт тавих зэрэг боломжийг олгоно.
- Улирлын ДНБ-ий тооцоо нь жилийн төлөв байдлыг урьдчилан тодорхойлоход цаг хугацааны хувьд тохиромжтой.
- Улирлын мэдээлэл нь эдийн засгийн үзүүлэлтүүдийн хоорондын динамик холбоог илүү харуулах бөгөөд жилийн туршид хийгдэх 4 удаагийн тооцоо нь корреляц, регресс гэх мэт математик-статистикийн аргыг хэрэглэхэд зохимжтой байдаг.

ДНБ-ий улирлын тооцоонд салбаруудын жилийн болон богино хугацааны үзүүлэлтүүдийн аль аль нь ашиглагдана.

ХОЁР. ДНБ-ИЙГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АРГААР, УЛИРЛААР ТООЦОХ АРГА ЗҮЙ

2.1 Ерөнхий зарчим

ДНБ-ий улирлын тооцоо нь жилийн тооцоотой харилцан үялдаатай байна.

ДНБ-ийг улирлаар тооцоход дараах зарчмыг баримтлана.

1. Тухайн салбарын жилийн үйл ажиллагааны улирлын динамик өөрчлөлтийг харуулж чадах богино хугацааны үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг тооцоололд сонгож авна. Мэдээллийн боломжоос шалтгаалан салбарын үндсэн үзүүлэлтүүдийг ашиглан, тэдгээрийн хандлагад үндэслэн салбарын нэмэгдэл өртгийг тооцно.
2. Дөрвөн улирлаар тооцсон ДНБ-ий жилийн гүйцэтгэл ДНБ-ий жилийн жинхэнэ гүйцэтгэлтэй тэнцүү байна.
3. ДНБ-ийг улирлаар тооцоход улирлын нөлөөллийг арилгасан тооцооллыг давхар гүйцэтгэнэ. Энэ нь улс орны онцлогоос хамаарч, эдийн засгийн салбаруудын үйл ажиллагаа нь улирлын нөлөөлөлтэй байдагтай холбоотой. ДНБ-ий улирлын тооцоог улирлын хэлбэлзлийг арилгасан, улирлын хэлбэлзэлтэй гэсэн 2 хувилбараар хийнэ.

Салбарын үндсэн үзүүлэлтийн хандлага, өөрчлөлтөд тулгуурлан ДНБ-ийг улирлаар тооцоход тооцооны гол хэрэгсэл болох Бенч¹ программыг, ДНБ-ий улирлын хэлбэлзлийг арилгаж тооцоход Х12-Арима төрлийн программыг тус тус ашиглана.

¹ Бенч программыг Канад улсын Статистикийн газар, Х12-Арима программыг АНУ-ын тооллогын товчоо зохиосон.

Улирлын нэмэгдэл өртгийг тооцох ерөнхий зарчим

Улирлын нэмэгдэл өртгийн хэмжээг тооцохдоо улирлын үндсэн үзүүлэлтийн хэмжээг VI -харьцаа буюу өмнөх оны улирлын нэмэгдэл өртөг болон салбарын үндсэн үзүүлэлтийн харьцаагаар үржүүлж тооцно.

$$VA_t = I_t * \frac{VA_{t-1}}{I_{t-1}} = VA_{t-1} * EI_t$$

$\frac{VA}{I}$ - VI харьцаа буюу нэмэгдэл өртөг, үндсэн үзүүлэлтийн харьцаа

VA – нэмэгдэл өртгийн хэмжээ

I – салбарын үндсэн үзүүлэлтийн хэмжээ

$EI_t = \frac{I_t}{I_{t-1}}$ - экстраполятор буюу салбарын үндсэн үзүүлэлтийн өсөлт

$t (t-1)$ – тайлант он (тайлант оны өмнөх жил)

Жишээ нь, аж үйлдвэрийн салбарын үндсэн үзүүлэлт нь салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээ байна гэе. Тайлант улирлын нэмэгдэл өртгийг тооцохдоо тайлант улирлын нийт үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны нэмэгдэл өртөг нийт үйлдвэрлэлийн харьцаагаар үржүүлнэ, эсвэл өмнөх оны нэмэгдэл өртгийн хэмжээг нийт үйлдвэрлэлийн өсөлтөөр үржүүлж тооцно.

Богино хугацааны үндсэн үзүүлэлт тооцдог бүх салбарын хувьд салбарын нэмэгдэл өртгийг улирлаар тооцохдоо дээрх аргыг ашиглана. Иймд салбар тус бүр дээр тухайн салбарын үйл ажиллагааг төлөөлж чадах улирлын үндсэн үзүүлэлтийг бий болгож, тооцоонд ашиглана.

Улирлын болон жилийн гүйцэтгэлийн уялдаа холбоо хэр сайн байх нь улирлын мэдээллийн чанараас ихээхэн шалтгаална. Сар, улирлын мэдээллүүд нь гол төлөв богино хугацаанд урьдчилсан гүйцэтгэлээр гарна. Салбарын мэдээллийг тодотгож шинэчилсэн тохиолдолд ДНБ-ий улирлын тооцоог мөн шинэчилнэ.

Улирлын ДНБ-ий тооцоог эдийн засгийн үйл ажиллагааны 19 салбараар хийнэ. Үндсэн мэдээллийн эх үүсвэрээс шалтгаалан салбаруудад өөр өөр арга ашиглагдана.

Нэмэгдэл өртгийн **оны үнийн** тооцоонд ашигладаг гол арга бол:

1. Нэмэгдэл өртгийн харьцааны арга

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

GO_{ct} – тайлант оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

VAR – өмнөх оны НӨ, НҮ-ийн харьцаа

2. Экстраполяцийн арга

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр (өмнөх оны хугацаа нь тайлант оны мөн үеийнхтэй ижил байна)

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

3. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг шилжүүлэх арга

$$VA_{ct} = VA_{kt} * PI_t$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр
 PI_t – тайлант оны холбогдох үнийн индекс

Нэмэгдэл өртгийн **зэрэгцүүлэх үнийн** тооцоонд ашигладаг гол арга бол:

1. Тоо хэмжээг дахин үнэлэх арга - тоо хэмжээний мэдээллийг суурь оны үнийг ашиглан дахин үнэлнэ.

$$GO_{kt} = Q_t * P_0$$

GO_{kt} - Нийт үйлдвэрлэл (НҮ), зэрэгцүүлэх үнээр

Q_t - бүтээгдэхүүний нэр төрлүүдийн тайлант оны биет хэмжээний гүйцэтгэл

P_0 - суурь оны бүтээгдэхүүн бүрийн үнэ

2. Дан дефляторын арга - оны үнээрх үзүүлэлтийг үнийн индекст хувааж зэрэгцүүлэх үнээр тооцно.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} - тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

3. Экстраполяцийн арга - өмнөх оны зэрэгцүүлэх үнээрх үзүүлэлтийг биет хэмжээний индексээр үржүүлэн тайлант оны зэрэгцүүлэх үнээр тооцно.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} - тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр (өмнөх оны хугацаа нь тайлант оны мөн үеийнхтэй ижил байна)

EI_{kt} – тайлант оны экстраполяц хийх биет хэмжээний үзүүлэлт

2.2 Салбаруудын нэмэгдэл өртгийг оны болон зэрэгцүүлэх үнээр тооцох.

2.2.1 Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар

2.2.1.а Газар тариалан, мал аж ахуйн салбар

1.Тооцох зарчим:

Салбарын нэмэгдэл өртөг нь тухайн улирал бүрийн нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээний ялгавар байна.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

2.2.1.1 Газар тариалан

Газар тариалангийн үйлдвэрлэл нь жилийн турш үргэлжилдэг онцлогтой тул тус салбарын улирлын нэмэгдэл өртгийг тооцоолтонд эхлээд тухайн жилийн нэмэгдэл өртгийг урьдчилсан байдлаар нэгтгэн гаргах шаардлагатай болдог. Үүний тулд салбарын өмнөх жилийн динамик үзүүлэлтэнд суурилан тухайн жилийн ургацын урьдчилсан балансыг гаргана. Ургацын балансад үндэслэн “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон Үндэсний нийт орлого тооцох аргачлал”-д тусгасны дагуу ургацын төрлүүдээр нийт үйлдвэрлэлийн тооцоог гаргана. Өмнөх онуудын мэдээлэлд үндэслэн экстраполяцийн аргыг ашиглан тооцооллыг хийнэ.

Жилийн турш явцын дунд урьдчилсан гүйцэтгэлийн тооцоог шинэчлэн тодотгол хийнэ.

Салбарын нэмэгдэл өртгийг улирлаар тооцохдоо улирал тус бүрийн нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээний ялгавар байна. Жилээр тооцогдсон нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээг улирлаар хуваарилахдаа тухайн улирлын зардлуудын хувийн жинг үндэслэнэ.

Газар тариалангийн салбарын зардлын бүтэц, ажлын үе шатаар

	хувь			
	I улирал Хөрс боловсруулалт	II улирал Тариалалт	III улирал Ургац хураалт	IV улирал Ургац хураалт, хөрс боловсруулалт
Цалин, холимог орлого	5.0	40.0	45.0	10.0
Үр, бордоо	5.0	95.0	-	-
Хортон устгалт	-	100.0	-	-
Түлш, шатахуун	5.0	50.0	30.0	15.0
Сэлбэг хэрэгсэл	15.0	30.0	50.0	5.0
Бусад	10.0	35.0	35.0	20.0

Газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээний улирлаар тооцох үндсэн зарчим нь:

1. Ургацын баланс дээр үндэслэн нийт үйлдвэрлэлийг тооцно.
2. Нийт үйлдвэрлэлийн зардлыг өмнөх оны бүтцийг үндэслэн тухайн оны дүнгээр тооцно.
3. Газар тариалангийн салбарын нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээ, нэмэгдэл өртгийг ажлын үе шатын улирлын зардлын бүтцийг ашиглан тооцно.

2.2.1.2 Мал аж ахуй

1. Тооцох зарчим:

Мал аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн улирлын тооцоо нь газар тариалангийн салбарын нэгэн адил жилийн нийт үйлдвэрлэлийн дүнг урьдчилан хийж, улмаар улирлуудаа хуваарилан гүйцэтгэнэ. Мал, тэжээвэр амьтдын тооны урьдчилсан тооцоог үндэлсэн малын ашиг шимийн бүтээгдэхүүн, малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүн болон бусад бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийг “ДНБ болон ҮНО тооцох аргачлал”-ын дагуу нэгтгэн гаргана.

Нийт үйлдвэрлэл:

Жилийн нийт үйлдвэрлэлийг улиралуудад тархаахдаа малын ашиг шим, малын өсөлт, үржилтийн бүтээгдэхүүн, бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл тус бүрээр хуваарилалт хийх ба улирлын гүйцэтгэлийг тооцно.

Мах үйлдвэрлэл: Махны хэрэглээ, мах үйлдвэрлэлийн онцлогийг харгалзан дараах байдлаар хуваарилна.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Мах үйлдвэрлэл	15%	13%	25%	47%

Сүү үйлдвэрлэл: Мал аж ахуйн салбарын онцлогоос хамаарч сүү үйлдвэрлэлийг дараах байдлаар улирлаар хуваарилна.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Сүү үйлдвэрлэл	10%	20%	50%	20%

Ноос үйлдвэрлэл: Ноос үйлдвэрлэлийн хувьд хонины ноосыг ихэвчлэн 7 дугаар сард, хониноос бусад малын ноос, ноолуурыг 3-6 сард бэлтгэж байгаа улирлын онцлогийн дагуу ноос үйлдвэрлэлийн хэмжээг улирлын хуваарилалт нь:

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Хонины ноос			100%	
Ямааны ноолуур	30%	70%		
Бусад		100%		

Арьс үйлдвэрлэл: Мах үйлдвэрлэлийн улирлын шинж чанарыг баримтлана.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Арьс үйлдвэрлэл	15%	13%	25%	47%

Шинээр нэмэгдсэн төл: Олон жилийн динамик мэдээлэлд үндэслэн шинээр нэмэгдэх төлийн тоо мал төллөлтийг дараах байдлаар хуваарилагддаг.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Бог мал	7%	89%	4%	-
Бод мал	27%	72%	1%	-

Өндөг үйлдвэрлэл: Өрхийн аж ахуйн хэрэглээг үндэслэн өндөг үйлдвэрлэлийг хувиарлалт нь:

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Өндөгний хэрэглээ	22.2%	26.1%	26.3%	25.4%

Бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл: МАА-н салбарын бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн улирлын хуваарилалт нь:

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Мал, амьтдын өсөлт	25%	25%	25%	25%
Зөгийн бал	-	-	100%	-
Бугын эвэр	-	100%	-	-
Үслэг арьс	50%	-	-	50%
Өтөг бууц, аргал, хөрсөн	30%	25%	20%	25%

Завсрын хэрэглээ:

Мал аж ахуйн салбар дахь завсрын хэрэглээний улирлын хуваарилалт нь малын тэжээлээс бусад зардлын хувьд ижил тэнцүүгээр, бэлчээрийн мал аж ахуйн онцлогийг харгалзан малын тэжээлийн учир харилцан адилгүйгээр улирлуудад хуваарилалт улирал бүрд өөр байна.

	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Малын тэжээл	40%	30%	5%	25%
Бусад зардал	25%	25%	25%	25%

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээр нэмэгдэл өртгийн тооцоог хийхдээ **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} - тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} - өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь

Оны үнээр тооцсон нэмэгдэл өртгийн улирлуудын хувийн жинг ашиглан зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийн хэмжээг улирлаар хуваарилна.

2. Мэдээллийн эх үүсвэр:

Мал төллөлт, төл бойжилт (ХАА-1), Том малын зүй бус хорогдол (ХАА-2), Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн сарын мэдээ (ХАА-3), Хөдөө аж ахуйн компани, хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын тайлан (ХАА-4), Жимс, жимсгэний тариалсан талбай, хураасан ургацын мэдээ (ХАА-5), Ургац хураалт, хадлан, тэжээл бэлтгэлийн мэдээ (ХАА-9), Аж ахуйн нэгжийн хураасан ургацын эцсийн мэдээ (ХАА-10а), Өрх, хувиараа эрхлэх аж ахуйн хураасан ургацын эцсийн мэдээ (ХАА-10б), ҮХААЯ-ны “Уринш элдэншүүлэлтийн сарын хагасын мэдээ” болон өмнөх оны нийт үйлдвэрлэл, завсрын хэрэглээний зардлын бүтэц зэрэг байна.

2.2.1.6 Ан агнуур, ойн аж ахуй, загасны аж ахуй

1. Тооцох зарчим:

Салбарын нэмэгдэл өртөг нь эхлээд зэрэгцүүлэх үнээр, дараа нь оны үнээр тооцно.

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээр нэмэгдэл өртгийг тооцохдоо **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} - тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} - өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Ан агнуур, ойн аж ахуй, загасны аж ахуй зэрэг салбаруудын нэмэгдэл өртгийг тооцохдоо сүүлийн онуудын жилийн дундаж өсөлтийг ашиглан тооцно. Улирлуудад хуваарилахдаа жилийн гүйцэтгэлийг тэнцүү 4-т хуваана.

2. Мэдээллийн эх үүсвэр:

Салбарын өмнөх онуудын нэмэгдэл өртгийн тооцоо.

2.2.2 Уул уурхай, олборлолт

Уул уурхай, олборлох салбар нь нүүрс, газрын тос, металлын хүдэр болон бусад ашигт малтмал олборлох салбар болон уул уурхайн олборлолтын туслах үйл ажиллагаанаас бүрдэнэ. Улирлын тооцоог хийхдээ дараах 2 үйл ажиллагаагаар тус тусад нь тооцож, нийлбэрээр авна.

(а). Олборлох салбар – эрдэс баялгийг олборлох уул уурхайн үйл ажиллагаа.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Уул уурхай, олборлох салбарын оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **нэмэгдэл өртгийн харьцааны аргыг** ашиглана. Ө.х. салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны оны үнээрх НӨ, НҮ-ийн харьцаагаар үржүүлнэ.

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct} – тайлант оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

$$VAR = \frac{VA_{ct-1}}{GO_{ct-1}}$$

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct-1} – өмнөх оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцох үндсэн 2 арга байдаг.

1. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

$$EI_{kt} = \frac{\sum Q_t P_0}{\sum Q_{t-1} P_0}$$

EI_{kt} – тайлант оны экстраполяц

Q_t – тайлант оны бүтээгдэхүүний биет хэмжээ

Q_{t-1} – өмнөх оны бүтээгдэхүүний биет хэмжээ

P_0 – суурь оны бүтээгдэхүүний үнэ

2. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн индекс (IPI) байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

(б). Уул уурхайн олборлолтын туслах үйл ажиллагаа – олборлох үйлдвэрлэлийн туслах үйлчилгээ болох өрөмдлөг, геологи хайгуул хийх үйл ажиллагаа орно.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Уул уурхайн олборлолтын туслах үйл ажиллагааны дэд салбарын оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **нэмэгдэл өртгийн харьцааны аргыг** ашиглана. Ө.х. геологи хайгуулын ажлын хэмжээг өмнөх оны үнээрх НӨ, жилийн геологи хайгуулын ажлын хэмжээний харьцаагаар үржүүлнэ.

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct} – тайлант нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

$$VAR = \frac{VA_{ct-1}}{GO_{ct-1}}$$

VA_{ct-1} – өмнөх оны хугацааны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct-1} – өмнөх оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь ХҮИ байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр
 VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 DI_t – тайлант оны дефлятор

2.2.3 Боловсруулах үйлдвэрлэл

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Боловсруулах салбарын оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **нэмэгдэл өртгийн харьцааны аргыг** ашиглана. Ө.х. салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны оны үнээрх НӨ, НҮ-ийн харьцаагаар үржүүлнэ.

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct} – тайлант оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

$$VAR = \frac{VA_{ct-1}}{GO_{ct-1}}$$

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct-1} – өмнөх оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцох үндсэн 2 арга байдаг.

1. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцох **экстраполяцийн арга**. Энэ аргын үед экстраполятор нь зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр
 VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

$$EI_{kt} = \frac{\sum Q_t P_0}{\sum Q_{t-1} P_0} - \text{тайлант оны зэрэгцүүлэх үнээрх НҮ-ийн өсөлтийн хувь}$$

Q_t – тайлант оны бүтээгдэхүүний биет хэмжээ
 Q_{t-1} – өмнөх оны бүтээгдэхүүний биет хэмжээ
 P_0 – суурь оны бүтээгдэхүүний үнэ

2. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцох **дан дефляторын арга**. Энэ аргын үед дефлятор нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн индекс (IPI) байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2. Мэдээллийн эх үүсвэр:

Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ (AY-1)

2.2.4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Цахилгаан, хий, уур, агааржуулалтын салбарын оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **нэмэгдэл өртгийн харьцааны аргыг** ашиглана. Ө.х. салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны оны үнээрх НӨ, НҮ-ийн харьцаагаар үржүүлнэ.

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

GO_{ct} – тайлант оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

$$VAR = \frac{VA_{ct-1}}{GO_{ct-1}} - \text{өмнөх оны НӨ, НҮ-ийн харьцаа}$$

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

GO_{ct-1} – өмнөх оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцох үндсэн 2 арга байдаг.

1. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

$$EI_{kt} = \frac{\sum Q_t P_0}{\sum Q_{t-1} P_0} - \text{тайлант оны зэрэгцүүлэх үнээрх НҮ-ийн өсөлтийн хувь}$$

Q_t – тайлант оны бүтээгдэхүүний биет хэмжээ

Q_{t-1} – өмнөх оны бүтээгдэхүүний биет хэмжээ

P_0 – суурь оны бүтээгдэхүүний үнэ

2. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн индекс (IPI) байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2. Мэдээллийн эх үүсвэр:

Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ (АҮ-1)

2.2.5 Ус хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа

Улирлын тооцоог хийхдээ дараах 2 үйл ажиллагаагаар тус тусад нь тооцож, нийлбэрээр авна.

(а). Ус хангамж, цэвэрлэх үйл ажиллагаа

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Ус хангамжийн салбарын оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **нэмэгдэл өртгийн харьцааны аргыг** ашиглана. Ө.х. салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны үнээрх НӨ, НҮ-ийн харьцаагаар үржүүлнэ.

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

GO_{ct} – тайлант оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

$$VAR = \frac{VA_{ct-1}}{GO_{ct-1}}$$

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

GO_{ct-1} – өмнөх оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцох үндсэн 2 арга байдаг.

1. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн өсөлтийн хувь байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

$$EI_{kt} = \frac{\sum Q_t P_0}{\sum Q_{t-1} P_0} - \text{тайлант оны зэрэгцүүлэх үнээрх НҮ-ийн өсөлтийн хувь}$$

Q_t – тайлант оны бүтээгдэхүүний биет хэмжээ

Q_{t-1} – өмнөх оны бүтээгдэхүүний биет хэмжээ

P_0 – бүтээгдэхүүний суурь оны үнэ

2. Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн индекс (IPI) байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

(б). Хог хаягдлыг цуглуулах, цэвэрлэх үйл ажиллагаа

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Салбарын оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **нэмэгдэл өртгийн харьцааны аргыг** ашиглана. Ө.х. орон сууц, нийтийн аж ахуйн салбарын нийт үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны оны үнээрх НӨ, НҮ-ийн харьцаагаар үржүүлнэ.

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

GO_{ct} – тайлант оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

$$VAR = \frac{VA_{ct-1}}{GO_{ct-1}} - \text{өмнөх оны НӨ, НҮ-ийн харьцаа}$$

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

GO_{ct-1} – өмнөх оны хугацааны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь ХҮИ байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2. Мэдээллийн эх үүсвэр:

Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ (AY-1), Орон сууц, нийтийн аж ахуйн орлого, зардлын улирлын мэдээ (ОСНАА-1), Үйлдвэрлэгчийн үнийн сарын мэдээ (ҮҮМ-1) мэдээлэл байна.

2.2.6 Барилга

Нэмэгдэл өртгийг эхлээд оны үнээр, дараа нь зэрэгцүүлэх үнээр тооцно.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Барилгын салбарын оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **нэмэгдэл өртгийн харьцааны аргыг** ашиглана. Ө.х. барилга угсралт, их засварын ажлын хэмжээг өмнөх оны оны үнээрх НӨ, НҮ-ийн харьцаагаар тодорхойлно.

$$VA_{ct} = GO_{ct} * VAR$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct} – тайлант оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

$$VAR = \frac{VA_{ct-1}}{GO_{ct-1}} - \text{өмнөх оны НӨ, НҮ-ийн харьцаа}$$

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 GO_{ct-1} – өмнөх оны нийт үйлдвэрлэл (НҮ), оны үнээр

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь барилгын өртгийн индекс байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр
 VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 DI_t – тайлант оны дефлятор

2.Мэдээллийн эх үүсвэр:

Барилга угсралт, их засварын ажлын улирлын мэдээ (ИБ-1), Барилгын материалын үнэ, цагийн дундаж цалин, механизмын зардлын улирлын мэдээ (ИБ-3б) маягтаар цуглуулсан мэдээлэлд үндэслэнэ.

2.2.7 Бөөний болон жижиглэнгийн худалдаа

Эхлээд оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцоод дараа нь зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцно.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо экстраполяцийн аргыг ашиглана. Экстраполяторыг худалдааны салбарын нийт борлуулалтаар тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн худалдааны салбарын нийт борлуулалт / өмнөх оны мөн үеийн худалдааны салбарын нийт борлуулалт

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 VA_{ct-1} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

$$EI_{ct} = \frac{НБ_t}{НБ_{(t-1)}}$$

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр
 $НБ_t$ – тайлант оны нийт борлуулалт
 $НБ_{t-1}$ – өмнөх оны нийт борлуулалт

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь ХҮИ байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр
 DI_t – тайлант оны дефлятор

2. Мэдээллийн эх үүсвэр.

“Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын улирлын мэдээ” (ХУ-1а) мэдээллийн эх үүсвэр болно.

Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа

Тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарын нэмэгдэл өртгийг дэд салбар бүрээр тооцно. Тээврийн салбар нь дотроо төмөр замын тээвэр, хуурай замын тээвэр, усан замын тээвэр, агаарын тээвэр, агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа болон шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа гэсэн дэд салбартай.

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргаар тооцно. Салбар нь дотроо үндсэн 4 хэсэгт хуваагдана: тээвэр, агуулах, ачаа ачих, буулгах болон тээврийн бусад үйлчилгээ, шуудангийн үйлчилгээ. Манай орны хувьд бие даасан агуулахын салбарын үйл ажиллагаа салбарын хэмжээнд хөгжөөгүй, туслах үйл ажиллагаа хэлбэрээр явагдаж, ААН-ийнхээ үндсэн үйл ажиллагаанд багтдаг.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц хийх биет хэмжээний үзүүлэлт

1. Шилжүүлсэн т/км, ачаа болон зорчигчийн тарифын өсөлтийн хувь, тээврийн туслах үйлчилгээний үйл ажиллагааны орлогын зэрэгцүүлэх үнээрх өсөлтийн хувь, шуудангийн үйлчилгээний нийт хэмжээний өсөлтийн хувийг тус тусад нь ашиглан жигнэсэн дундаж өсөлтийн хувийг тооцно, жин нь өмнөх оны дээрх 3 дэд салбарт эзлэх НӨ-ийн хувийн жин байна.
2. Экстраполяторыг өмнөх оны зэрэгцүүлэх үнээрх салбарын НӨ болон жигнэсэн дундаж өсөлтийн хувиар үржүүлж тооцно.

$$EI_{kt} = I_{wt} * VA_0$$

EI_{kt} – тайлант оны экстраполяц хийх биет хэмжээний үзүүлэлт

I_{wt} – жигнэсэн дундаж

VA_0 - өмнөх оны зэрэгцүүлэх үнээрх салбарын НӨ

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргыг ашиглан тооцно. Экстраполяторыг тээврийн салбарын нийт орлогоор тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн тээврийн салбарын нийт орлого / өмнөх оны мөн үеийн тээврийн салбарын нийт орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

$$EI_{ct} = \frac{HO_t}{HO_{(t-1)}}$$

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

HO_t - тайлант оны тээврийн салбарын нийт орлого

HO_{t-1} - өмнөх оны мөн үеийн тээврийн салбарын нийт орлого

Тээврийн үйл ажиллагаатай холбоотой бусад туслах үйл ажиллагааны салбарын хувьд улирлын тооцоог хийхдээ нэмэгдэл өртгийн жилийн тооцоог өмнөх онуудын өсөлтийн хандлага дээр үндэслэн урьдчилан тооцно. Дараа нь улирлуудад тэнцүү хуваарилна.

2.Мэдээллийн эх үүсвэр:

Авто, усан замын тээврийн тээвэрлэлтийн улирлын мэдээ (Т-1), Агаарын тээврийн тээвэрлэлтийн сарын мэдээ (АТ-7), Төмөр замын тээвэрлэлтийн сарын мэдээ (Т-9), Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний улирлын тайлан (ШХИҮ-1) мэдээллийн эх үүсвэр болно.

2.2.8 Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ

Эхлээд оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцоод дараа нь зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцно.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг **экстраполяцийн аргыг** ашиглан тооцно. Зочид буудлын экстраполяторыг зочид буудлын орлогоор тодорхойлно.

Нийтийн хоолны үйлчилгээний экстраполяторыг нийтийн хоолны салбарын орлогоор тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн зочид буудал (нийтийн хоолны үйлчилгээ)-ын орлого / өмнөх оны мөн үеийн зочид буудал (нийтийн хоолны үйлчилгээ)-ын орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

$$EI_{ct} = \frac{Rev_t}{Rev_{(t-1)}}$$

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

Rev_t - тайлант оны зочид буудал (нийтийн хоолны үйлчилгээ)-ын орлого

Rev_{t-1} - өмнөх оны зочид буудал (нийтийн хоолны үйлчилгээ)-ын орлого

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо дан дефляторын аргыг ашиглана. Зочид буудлын дефлятор нь ХҮИ-ийн зочид буудал, дотуур байрны үйлчилгээний суурь оныхтой харьцсан индекс байна. Нийтийн хоолны

үйлчилгээний дефлятор нь ХҮИ-ийн нийтийн хоолны үйлчилгээ"-ий суурь оныхтой харьцсан индекс байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2.Мэдээллийн эх үүсвэр.

Зочид буудлын үйл ажиллагааны улирлын тайлан (ЗБ-1а), Зоогийн газрын үйл ажиллагааны улирлын тайлан (ЗГ-1а) мэдээллийн эх үүсвэр болно.

2.2.10 Мэдээлэл, холбоо

Мэдээлэл, холбооны салбарын нэмэгдэл өртгийг дэд салбар бүрээр тооцно.

Мэдээлэл, холбооны салбар нь 5 дэд салбартай. Үүнд:

- Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа
- Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа
- Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа
- Цахилгаан холбоо
- Компьютер програмчлал, зөвлөгөө өгөх үйл ажиллагаа болон түүнд холбогдох үйл ажиллагаа

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргаар тооцно.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц

1. Холбооны нийт хэмжээний өсөлтийн хувь, компьютерийн үйлчилгээний үйл ажиллагааны орлогын зэрэгцүүлэх үнээрх өсөлтийн хувь, эх бэлтгэх, нийтлэх үйлчилгээний нийт хэмжээний өсөлтийн хувийг тус тусад нь ашиглан жигнэсэн дундаж индексийг тооцно, жин нь суурь оны дээрх 3 дэд салбарт эзлэх НӨ-ийн хувийн жин байна.
2. Жигнэсэн дундаж индексийг суурь оны салбарын НӨ-ийн хэмжээгээр үржүүлж экстраполяторыг тооцно.

$$EI_{kt} = I_{wt} * VA_0$$

EI_{kt} – t хугацааны экстраполятор, оны үнээр

I_{wt} – жигнэсэн дундаж

VA_0 - өмнөх оны зэрэгцүүлэх үнээрх салбарын НӨ

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргыг ашиглан тооцно. Мэдээлэл, холбооны салбарын экстраполяторыг гаргаж авахдаа холбооны орлогын өсөлтөөр тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн холбооны орлого / өмнөх оны мөн үеийн холбооны орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

$$EI_{ct} = \frac{Rev_t}{Rev_{(t-1)}}$$

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

Rev_t - тайлант оны холбооны орлого

Rev_{t-1} - өмнөх оны мөн үеийн холбооны орлого

2.Мэдээллийн эх үүсвэр:

Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үйлчилгээний улирлын тайлан (ШХИҮ-1) мэдээллийн эх үүсвэр болно.

2.2.11 Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа

Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарт банк, банк бус санхүүгийн үйл ажиллагаа, даатгал, бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа хамрагдана.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Банк, бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа, даатгалын салбарын нэмэгдэл өртгийг салбар тус бүрээр **экстраполяцийн аргыг** ашиглан тооцно. Үүнд, банк, бусад санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны экстраполяторыг хадгаламж болон зээлийн хэмжээний өөрчлөлтөөр тодорхойлно.

Үнэт цаас, брокерийн үйл ажиллагааны экстраполяторыг хувьцааны арилжааны нийт борлуулалтын орлогын өөрчлөлтөөр тодорхойлно.

Даатгалын үйл ажиллагааны экстраполяторыг даатгалын орлогын өөрчлөлтөөр тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн холбогдох үзүүлэлтийн хэмжээ (хадгаламж болон зээл, арилжсан хувьцаа, даатгалын орлого) / өмнөх оны мөн үеийн холбогдох үзүүлэлтүүдийн хэмжээ

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

$$EI_{ct} = \frac{Ind_t}{Ind_{(t-1)}}$$

Ind_t – тайлант оны салбарын холбогдох үзүүлэлт

Ind_{t-1} – өмнөх оны салбарын холбогдох үзүүлэлт

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо дан дефляторын аргыг ашиглана. Дефлятор нь ХҮИ-ийн үйлчилгээний үнийн индекс байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2. Мэдээллийн эх үүсвэр.

Монголбанкны “Статистикийн сарын бюллетень”, Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг ААНБ-ын үйл ажиллагааны улирлын мэдээ (БЗҮ-1а), Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны улирлын мэдээ (ХЗХ-1), Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ (ББСБ-1), Даатгалын байгууллагын улирлын үйл ажиллагааны тайлан (Д-1) мэдээ байна.

2.2.12 Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт дараах үйл ажиллагаа орно.

- Өөрийн болон лизингийн үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
- Өөрийн эзэмшлийн орон сууцны түрээсийн тооцоо

Нэмэгдэл өртгийг тус тусад нь тооцоод нэмнэ.

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг **экстраполяцийн аргаар** тооцно.

1. Өөрийн болон лизингийн үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц

1. Тухайн салбарын улирлын мэдээлэл байхгүй тул сүүлийн жилүүдийн дундаж өсөлт ашиглан НӨ-ийг урьдчилан тооцно.
2. Экстраполяторыг НӨ-ийн өсөлтийн хувиар тодорхойлно.

$$EI_{kt} = \frac{VA_t^*}{VA_{(t-1)}}$$

VA_t – тайлант оны нэмэгдэл өртөг,

VA_{t-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг

2. Өөрийн эзэмшлийн орон сууцны түрээсийн тооцоо

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц

Өсөлтийг тооцохдоо хүн амын тооны өсөлтийн хувийг ашиглана. Жилийн эцэст байх хүн амын тоон дээр үндэслэн улирлуудын хүн амын тоог тооцно.

Экстраполяторыг хүн амын өсөлтийн индексийг суурь оны НӨ-ийн хэмжээгээр үржүүлж тооцно.

$$EI_{kt} = I_{pop} * VA_0$$

I_{pop} – хүн амын өсөлтийн индекс

VA_0 – суурь оны нэмэгдэл өртөг

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг шилжүүлэх аргыг** ашиглана.

$$VA_{ct} = VA_{kt} * PI_t$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

PI_t -ХҮИ-ийн орон сууцны бодит түрээсийн индекс

2.Мэдээллийн эх үүсвэр: Салбарын нэмэгдэл өртгийн өмнөх оны мэдээлэл, хүн амын урьдчилсан тоо, ХҮИ.

1.2.13 Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа

Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар нь 7 дэд салбартай. Үүнд:

- Хуулийн болон бүртгэлийн үйл ажиллагаа
- ААН-ийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа; менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
- Архитектур болон инженерийн үйл ажиллагаа; техникийн туршилт, шинжилгээ
- ШУ-ны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны үйл ажиллагаа
- Сурталчилгааны ажил, зах зээлийн судалгаа
- Мэргэжлийн, ШУТ-ийн ажлын бусад үйл ажиллагаа
- Мал эмнэлгийн үйл ажиллагаа

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргыг ашиглан дэд салбар тус бүр дээр тооцно. Экстраполяторыг дэд салбарын үйл ажиллагааны орлогоор

тодорхойлно. Экстраполятор = тайлант үеийн үйл ажиллагааны орлого / өмнөх оны мөн үеийн үйл ажиллагааны орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг, оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, оны үнээр

$$EI_{ct} = \frac{Rev_t}{Rev_{(t-1)}}$$

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

Rev_t - тайлант оны үйл ажиллагааны орлого

Rev_{t-1} - өмнөх оны мөн үеийн ажиллагааны орлого

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо дан дефляторын аргыг ашиглана. Дефлятор нь ХҮИ-ийн үйлчилгээний үнийн индекс байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2.Мэдээллийн эх үүсвэр:

Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн орлого, зарлагын улирлын мэдээ (ЭШС-1), Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ, Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын тайлан (МЭ-1).

1.2.14 Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа

Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар нь 6 дэд салбартай. Үүнд:

- Түрээс, лизингийн үйл ажиллагаа
- Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа
- Аялал жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа
- Аюулгүйн хамгаалал, мөрдөх үйл ажиллагаа
- Байшин, барилга болон цэцэрлэг, газрын гадаргыг арчлах, хамгаалах үйл ажиллагаа
- Албан байгууллагын удирдлагын болон туслах үйл ажиллагаа, бизнесийн бусад туслах үйл ажиллагаа

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргыг ашиглан дэд салбар тус бүр дээр тооцно. Экстраполяторыг дэд салбарын үйл ажиллагааны орлогоор тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн үйл ажиллагааны орлого / өмнөх оны мөн үеийн үйл ажиллагааны орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг, оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, оны үнээр

$$EI_{ct} = \frac{Rev_t}{Rev_{(t-1)}}$$

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

Rev_t - тайлант оны үйл ажиллагааны орлого

Rev_{t-1} - өмнөх оны мөн үеийн ажиллагааны орлого

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо дан дефляторын аргыг ашиглана. Дефлятор нь ХҮИ-ийн үйлчилгээний дэд хэсгийн үнийн индекс байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2.Мэдээллийн эх үүсвэр:

Аялал жуулчлалын салбарын орлого, зардлын улирлын судалгаа, салбарын НӨ-ийн урьдчилсан тооцоо.

1.2.15 Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргыг ашиглан тооцно.

Экстраполяторыг төсөвт байгууллагын ажиллагчдын орлого буюу улсын нэгдсэн төсөв дэх ажиллагчдын цалин болон ажил олгогчоос төлсөн НДШ-ийн зардлаар тодорхойлно. Төсвийн зардлын сарын мэдээ салбараар гардаггүй тул төсөвт байгууллагын нийт ажиллагчдын орлогоор тооцно. Ө.х. төрийн удирдлагын салбараас гадна боловсрол, эрүүл мэнд зэрэг салбарууд орно.

Экстраполятор = тайлант үеийн ажиллагчдын орлого / өмнөх оны мөн үеийн ажиллагчдын орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг, оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, оны үнээр

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

$$EI_{ct} = \frac{COE_t}{COE_{(t-1)}}$$

COE_t - тайлант оны ажиллагчдын орлого

COE_{t-1} - өмнөх оны ажиллагчдын орлого

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь ажиллагчдын тооны индексийг суурь оны НӨ-өөр үржүүлж тооцно.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц

$$EI_{kt} = I_{empl} * VA_0$$

I_{empl} - ажиллагчдын тооны индекс

VA_0 - суурь оны нэмэгдэл өртөг

2.Мэдээллийн эх үүсвэр:

Улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ үндсэн эх үүсвэр болно.

1.2.16 Боловсролын үйл ажиллагаа

Боловсролын салбар нь дотроо үндсэн 5 бүлэгтэй: сургуулийн өмнөх болон бага боловсрол, дунд боловсрол, дээд боловсрол, бусад боловсрол олгох үйл ажиллагаа болон боловсролын туслах үйл ажиллагаа.

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргаар тооцно.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц

1. Цэцэрлэгийн хүүхдийн тоо, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцагчдын тоо, их, дээд сургуульд суралцагчдын тооны өсөлтийн хувийг тус тусад нь ашиглан жигнэсэн дундаж өсөлтийн хувийг жилээр тооцно, жин нь өмнөх оны дээрх 3 дэд салбарт эзлэх НӨ-ийн хувийн жин байна.
2. Экстраполяторыг суралцагчдын тооны жигнэсэн дундаж өсөлтийн хувь болон суурь оны НӨ-ийн хэмжээгээр тооцно.

$$EI_{kt} = I_{wt} * VA_0$$

I_{wt} - жигнэсэн дундаж өсөлтийн хувь

VA_0 - суурь оны нэмэгдэл өртөг

3. Жилийн мэдээллийг улирлуудад хуваарилна. Суралцагчдын тоог улирлаар хуваарилахдаа тайлант оны 1-3 дугаар улиралд өмнөх хичээлийн шинэ жилийн суралцагчдын тоог, харин 4-р улиралд тайлант оны хичээлийн жилийн суралцагчдын тоог харгалзах үзүүлэлт болгож авна.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргаар тооцно.

Экстраполяторыг улсын нэгдсэн төсвийн ажиллагчдын цалин болон ажил олгогчоос төлсөн НДШ-ийн гүйцэтгэлээр тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн ажиллагчдын орлого / өмнөх оны мөн үеийн ажиллагчдын орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг, оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, оны үнээр

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

$$EI_{ct} = \frac{COE_t}{COE_{(t-1)}}$$

COE_t - тайлант оны ажиллагчдын орлого

COE_{t-1} - өмнөх оны ажиллагчдын орлого

2.Мэдээллийн эх үүсвэр.

Улсын болон орон нутгийн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ, Мэргэжлийн түр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн улирлын мэдээ (МТС-1).

1.2.17 Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргыг ашиглан тооцно.

Экстраполяторыг улсын нэгдсэн төсвийн ажиллагчдын цалин болон ажил олгогчоос төлсөн НДШ-ийн гүйцэтгэлээр тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн ажиллагчдын орлого / өмнөх оны мөн үеийн ажиллагчдын орлого

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг, оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, оны үнээр

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

$$EI_{ct} = \frac{COE_t}{COE_{(t-1)}}$$

COE_t - тайлант оны ажиллагчдын орлого

COE_{t-1} - өмнөх оны ажиллагчдын орлого

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь салбарын ажиллагчдын тооны индекс болон суурь оны нэмэгдэл өртгийн үржвэр байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц

$$EI_{kt} = I_{empl} * VA_0$$

I_{empl} - ажиллагчдын тооны индекс

VA_0 - суурь оны нэмэгдэл өртөг

2.Мэдээллийн эх үүсвэр:

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ, Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудын орлого, зарлагын улирлын, жилийн тайлан (ЭМТ-6).

1.2.18 Урлаг, үзвэр, тоглоом наадам

Урлаг, үзвэр, тоглоом наадмын салбар нь дараах дэд салбартай:

- Бүтээл туурвих, урлаг, үзвэр, үйлчилгээний үйл ажиллагаа
- Номын сан, архив, музей болон бусад соёлын үйл ажиллагаа
- Спорт, зугаа цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа

Нэмэгдэл өртгийг эхлээд оны үнээр, дараа нь зэрэгцүүлэх үнээр тооцно.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Уг салбарын нэмэгдэл өртгийн 80 орчим хувийг зах зээлийн бус үйлдвэрлэл буюу төсөвт байгууллагын үйл ажиллагаа бүрдүүлдэг. Иймд салбарын нийт үйлдвэрлэлийг зах зээлийн болон зах зээлийн бус гэж ангилж тооцно.

Оны үнээрх нэмэгдэл өртгийг экстраполяцийн аргыг ашиглан тооцно.

Экстраполяторыг зах зээлийн үйлдвэрлэлийн хувьд салбарын үйл ажиллагааны орлогоор, зах зээлийн бус үйлдвэрлэлийн хувьд улсын нэгдсэн төсвийн ажиллагчдын цалин болон ажил олгогчоос төлсөн НДШ-ийн гүйцэтгэлээр тус тус тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн үйл ажиллагааны орлого (ажиллагчдын орлого) / өмнөх оны мөн үеийн үйл ажиллагааны орлого (ажиллагчдын орлого)

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг, оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, оны үнээр

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

$$EI_{ct1} = \frac{Rev_t}{Rev_{(t-1)}}; EI_{ct2} = \frac{COE_t}{COE_{(t-1)}}$$

Rev_t - тайлант оны үйл ажиллагааны орлого

Rev_{t-1} - өмнөх оны мөн үеийн ажиллагааны орлого

COE_t - тайлант оны ажиллагчдын орлого

COE_{t-1} - өмнөх оны ажиллагчдын орлого

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зах зээлийн үйлдвэрлэл:

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь ХҮИ-ийн үйлчилгээний үнийн индекс байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

Зах зээлийн бус үйлдвэрлэл:

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **экстраполяцийн аргыг** ашиглана. Экстраполятор нь салбарын ажиллагчдын тооны индекс болон суурь оны нэмэгдэл өртгийн үржвэр байна.

$$VA_{kt} = VA_{kt-1} * EI_{kt}$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{kt-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

EI_{kt} – тайлант оны экстраполяц

$$EI_{kt} = I_{empl} * VA_0$$

I_{empl} - ажиллагчдын тооны индекс

VA_0 - суурь оны нэмэгдэл өртөг

2.Мэдээллийн эх үүсвэр:

Улсын төсвийн мэдээ, “Чөлөөт цаг, соёл, биеийн тамирын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн орлого, зарлагын улирлын мэдээ (СБТ-1) мэдээллийн эх үүсвэр болно.

1.2.19 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа

Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар нь дараах дэд салбартай:

- Гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа
- Хувийн болон өрхийн хэрэглээний зориулалттай бараа, компьютерийн засвар, үйлчилгээ
- Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа

Нэмэгдэл өртгийг эхлээд оны үнээр, дараа нь зэрэгцүүлэх үнээр тооцно.

Нэмэгдэл өртөг, оны үнээр

Оны үнээрх нэмэгдэл өртгийг дэд салбараар **экстраполяцийн аргыг** ашиглан тооцно.

Гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагааны салбарын экстраполяторыг сүм хийд, төрийн бус байгууллагын үйл ажиллагааны зардлаар тодорхойлно.

Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарын экстраполяторыг салбарын үйл ажиллагааны орлогоор тодорхойлно.

Экстраполятор = тайлант үеийн үйл ажиллагааны зардал (орлого) / өмнөх оны мөн үеийн үйл ажиллагааны зардал(орлого)

$$VA_{ct} = VA_{ct-1} * EI_{ct}$$

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг, оны үнээр

VA_{ct-1} – өмнөх оны нэмэгдэл өртөг, оны үнээр

EI_{ct} – тайлант оны экстраполятор, оны үнээр

$$EI_{ct1} = \frac{Exp_t}{Exp_{(t-1)}}; EI_{ct2} = \frac{Rev_t}{Rev_{(t-1)}}$$

Rev_t - тайлант оны үйл ажиллагааны орлого

Rev_{t-1} - өмнөх оны мөн үеийн ажиллагааны орлого

Exp_t - тайлант оны үйл ажиллагааны зардал

Exp_{t-1} - өмнөх оны мөн үеийн үйл ажиллагааны зардал

Нэмэгдэл өртөг, зэрэгцүүлэх үнээр

Зэрэгцүүлэх үнээрх нэмэгдэл өртгийг тооцохдоо **дан дефляторын аргыг** ашиглана. Дефлятор нь ХҮИ-ийн үйлчилгээний үнийн индекс байна.

$$VA_{kt} = VA_{ct} / DI_t$$

VA_{kt} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), зэрэгцүүлэх үнээр

VA_{ct} – тайлант оны нэмэгдэл өртөг (НӨ), оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

2.Мэдээллийн эх үүсвэр:

Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын тайлан (ТББ-1), Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн орлого, зардлын улирлын тайлан (НБХҮ-1), Сүм, хийдийн үйл ажиллагааны улирлын, жилийн тайлан (СХ-1) мэдээллийн эх үүсвэр болно.

1.2.20 Бүтээгдэхүүний татвар, татаас

Бүтээгдэхүүний цэвэр татвар, оны үнээр

Бүтээгдэхүүний цэвэр татварыг оны үнээр тооцоходоо улсын нэгдсэн төсвийн орлого, зардлын мэдээнээс дараах мэдээллийг авч тооцно.

1. Бүтээгдэхүүний татвар (1.1+1.2+1.3)

1.1 Нэмэгдсэн өртгийн албан татвар

- 1.1 Дотоодын бараа, үйлчилгээний
- 1.2 Импортын барааны
- 1.3 НӨАТ-ын буцаан олголт

1.2 Онцгой албан татвар

- 2.1 Дотоодын архины
- 2.2 Дотоодын тамхины
- 2.3 Автобензин, дизелийн түлшний
- 2.4 Импортын архи, тамхины
- 2.5 Импортын пивоны
- 2.6 Суудлын автомашины
- 2.7 Дотоодын пивоны

1.3 Гадаад худалдааны орлого

- 3.1 Импортын барааны гаалийн албан татвар
- 3.2 Экспортын гаалийн албан татвар

2. Бүтээгдэхүүний татаас (2.1+2.2+2.3)

- 2.1 Эрчим хүчний алдагдлын татаас
- 2.2 Хотын нийтийн тээврийн алдагдлын татаас
- 2.3 Улаанбуудай, махны татаас

3. Бүтээгдэхүүний цэвэр татвар (1-2)

Бүтээгдэхүүний цэвэр татвар, зэрэгцүүлэх үнээр

Бүтээгдэхүүний цэвэр татварыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ дараах 2 аргыг ашиглана.

- **Дефляторын арга:** Цуглуулсан татварын хэмжээг татварын дефляторт хуваана. Татварын дефлятор нь татварын хувь хэмжээний өөрчлөлт болон татвар ногдсон барааны үнийн өөрчлөлтийн үржвэрээр тодорхойлогдоно.

$$Tax_{kt} = Tax_{ct} / DI_t$$

Tax_{kt} – тайлант оны татварын хэмжээ, зэрэгцүүлэх үнээр

Tax_{ct} – тайлант оны татварын хэмжээ, оны үнээр

DI_t – тайлант оны дефлятор

- **Экстраполяцийн арга:** Суурь онд цуглуулсан татварын хэмжээг холбогдох бүтээгдэхүүний биет хэмжээний индексээр үржүүлнэ. Тухайлбал, дотоодын барааны архи, тамхи, пивоны онцгой татвар.

$$Tax_{kt} = Tax_0 * EI_{kt}$$

Tax_{kt} – тайлант оны татварын хэмжээ, зэрэгцүүлэх үнээр

Tax_{ct} – Суурь оны татварын хэмжээ, оны үнээр

Dl_t – тайлант оны дефлятор

Татаасын хувьд ижил арга ашиглана.

2. Мэдээллийн эх үүсвэр:

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ нь мэдээллийн эх үүсвэр болно.

ГУРАВ. ДНБ-ИЙГ ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААР, УЛИРЛААР, ОНЫ ҮНЭЭР ТООЦОХ АРГА ЗҮЙ

ДНБ-ий эцсийн ашиглалтын аргаар улирлаар тооцохдоо “ДНБ болон ҮНО тооцох аргачлал”-ыг тооцооны үндсэн зарчим болгоно.

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ нь дотроо өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагын хэрэглээ, үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал, бараа үйлчилгээний цэвэр экспорт гэсэн дэд хэсгүүдээс бүрдэнэ.

ДНБ-ий улирлын тооцоо нь жилийн тооцоотой харилцан уялдаатай байна. Иймээс улирлаар тооцсон ДНБ-ий гүйцэтгэлийг жилийн эцсийн жинхэнэ гүйцэтгэлээр дахин тодотгон тооцно.

4.1 Эцсийн хэрэглээ

Эцсийн хэрэглээ нь өрхийн аж ахуйн хэрэглээ, төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ, өрхийн аж ахуйд үйлчилдэг төрийн бус байгууллагын хэрэглээнээс бүрдэнэ. Эцсийн хэрэглээ нь эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-ий 60 орчим хувийг эзэлдэг гол бүрэлдэхүүн хэсэг юм.

А. Өрхийн аж ахуйн хэрэглээ

1. Тооцох зарчим.

Өрхийн аж ахуйн хэрэглээнд тайлант улиралд хүн амын худалдаж авсан хүнсний болон хүнсний бус бараа, үйлчилгээний зардлууд, өрхийн аж ахуйгаас биет байдлаар хэрэглэсэн бүтээгдэхүүн, бусдаас үнэгүй авсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, орон сууцны хийсвэр түрээсийн зардал, шууд бусаар хэмжих санхүүгийн зуучлалын үйлчилгээ зэрэг хамрагдана.

Тухайн тайлант улирлын өрхийн аж ахуйн нийт хэрэглээг тооцохдоо тухайн улирлын нэг өрхийн сарын дундаж хэрэглээг нийт 3 сараар болон тухайн жилийн нийт өрхийн тоогоор үржүүлж тооцно. Өрхийн аж ахуйн улирлын хэрэглээг дараах байдлаар тооцно.

	Өрхийн сарын дундаж хэрэглээ				Сарын тоо	Улсын хэмжээний нийт өрхийн тоо	Улирлын нийт хэрэглээ – Бүгд
	Худалдан авсан	Бусдаас үнэгүй авсан	Өөрийн аж ахуйгаас хэрэглэсэн бүтээгдэхүүн	Өрхийн нийт хэрэглээ			
	1	2	3	4	5	6	7
Хүнсний хэрэглээ							
Мах				1+2+3	3	N	4*5*6
Сүү				1+2+3	3	N	4*5*6

.....				1+2+3	3	N	4*5*6
Дүн				1+2+3	3	N	4*5*6
Хүнсний бус хэрэглээ							
Хувцас			X	1+2	3	N	4*5*6
Гутал			X	1+2	3	N	4*5*6
.....			X	1+2	3	N	4*5*6
Дүн			X	1+2	3	N	4*5*6

Хувийн орон сууцны хийсвэр түрээсийн зардлыг улирлаар тооцоходоо орон сууцны бодит түрээсийн, шууд бусаар хэмжих санхүүгийн зуучлалын үйлчилгээний зардлыг (FISIM) улирлаар тооцоход банк болон санхүүгийн бусад байгууллагаар үйлчлүүлсэн төлбөрийн улирлын бүтцийн хандлагыг ашиглана.

2. Мэдээллийн эх үүсвэр.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны улирлын мэдээлэл нь мэдээллийн эх үүсвэр болно.

Б. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ

1. Тооцох зарчим.

Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээг нийт үйлдвэрлэлт буюу төсөвт байгууллагын урсгал зардлын гүйцэтгэл, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын зөрүүгээр тооцно.

Улирал тус бүрийн хэрэглээг жилийн тооцоотой адил зарчмаар тооцно.

2. Мэдээллийн эх үүсвэр.

Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын улирлын гүйцэтгэл байна.

В. Төрийн бус байгууллагын хэрэглээ

1. Тооцох зарчим.

Төрийн бус байгууллагын хэрэглээг урсгал зардлаар нь тооцно.

Төрийн бус байгууллагын улирлын хэрэглээг жилийн тооцоотой адил зарчмаар тооцно.

2. Мэдээллийн эх үүсвэр.

“Төрийн бус байгууллагын орлого, зарлагын улирлын тайлан” ТББ-1, “Сүм хийдийн үйл ажиллагааны улирлын, жилийн тайлан” СХ-1 маягтаар авсан мэдээлэл болно.

4.2 Хөрөнгийн нийт хуримтлал

Хөрөнгийн нийт хуримтлал нь үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлалаас бүрддэг.

Үндсэн хөрөнгийн хуримтлал

1. Тооцох зарчим.

Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгааны мэдээлэлд үндсэн хөрөнгө нь дараах үзүүлэлтүүдээр тайлант хугацааны эхэн болон эцсийн байдлаар тусгагдсан байдаг бөгөөд эдгээрийн зөрүүгээр үндсэн хөрөнгийн хуримтлалыг тооцно. Үүнд:

Үндсэн хөрөнгийн хуримтлал тооцох үзүүлэлтүүд

	Мөрийн дугаар	Оны эхэнд	Оны эцэст	Зөрүү буюу ҮХХ* /2-1/
A	Б	1	2	3
Үндсэн хөрөнгө мөр 1 = мөр (2+3+7+11+12+15+16)	1			
Орон сууцны барилга	2			
Бусад барилга, байгууламж мөр 3 = мөр (4+5+6)	3			
Орон сууцны бус барилга	4			
Бусад байгууламж	5			
Газрын сайжруулалт	6			
Машин, тоног төхөөрөмж мөр 7 = мөр (8+9+10)	7			
Тээврийн хэрэгсэл	8			
Мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж	9			
Бусад машин, тоног төхөөрөмж	10			
Цэргийн зэр зэвсэг	11			
Биологийн өсөж үрждэг хөрөнгө мөр 12 = мөр (13+14)	12			
Мал, амьтан	13			
Олон наст ургамал	14			
Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгө эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал	15			
Оюуны өмчийн бүтээгдэхүүн мөр 16 = мөр (17+18+19+22+23)	16			
Шинжилгээ судалгаа, хөгжлийн ажил	17			
Геологи хайгуулын ажил болон үнэлгээ	18			
Компьютерийн программ хангамж, мэдээллийн сан мөр 19 = мөр (20+21)	19			
Компьютерийн программ хангамж	20			
Мэдээллийн сан	21			
Утга зохиол, урлагийн эх бүтээл	22			
Оюуны өмчийн бусад хөрөнгө	23			

2. Мэдээллийн эх үүсвэр:

Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгааны мэдээлэл, Барилгын салбарын улирлын мэдээлэл, гадаад худалдааны импортын мэдээлэл зэргийг ашиглана.

Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт

1. Тооцох зарчим.

Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгааны мэдээлэлд эргэлтийн хөрөнгө нь дараах үзүүлэлтүүдээр оны эхний болон эцсийн байдлаар тусгагдсан бөгөөд тэдгээрийн зөрүүгээр эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг тооцно. Үүнд:

Материаллаг эргэлтийн хөрөнгийн үзүүлэлтүүд

	мөрийн дугаар	оны эхэнд	оны эцэст	Зөрүү буюу МЭХӨ
А	Б	1	2	3=2-1
Материаллаг эргэлтийн хөрөнгө мөр 1 = мөр (2+3+4+7+8)	1			
Түүхий эд, материал	2			
Сэлбэг хэрэгсэл	3			
Дуусаагүй үйлдвэрлэл мөр 4 = мөр (5+6)	4			
Биологийн өсөж үрждэг хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл	5			
Дуусаагүй бусад үйлдвэрлэл	6			
Бэлэн бүтээгдэхүүн	7			
Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн	8			

Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийн улирлын тооцоонд үнийн өөрчлөлт буюу эргэлтийн хөрөнгө эзэмшсэний ашиг/алдагдлыг (holding gain/loss) тусгахгүй.

2. Мэдээллийн эх үүсвэр:

Аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө, хөрөнгө оруулалтын улирлын судалгааны мэдээлэл болно.

Үнэт зүйлсийн хуримтлал

1. Тооцох зарчим.

Үнэт зүйлсийн хуримтлалд үнэт металл, чулуу, эртний эдлэл, түүх, соёл, гар урлалын бүтээл, ном, эдлэл зэрэг тодорхой үнэ бүхий зүйлс орно. Үнэт зүйлсийн хуримтлалыг улирлаар тооцохдоо үйлдвэрлэсэн болон экспортод гаргасан алтны улирлын хандлагыг ашиглана.

2. Мэдээллийн эх үүсвэр:

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ- АҮ-1, гадаад худалдааны экспорт, импортын улирлын мэдээ болно.

4.3 Бараа, үйлчилгээний цэвэр экспорт

Эцсийн ашиглалтын аргаарх ДНБ-д бараа, үйлчилгээний гадаад худалдааны зөрүү буюу цэвэр экспортын дүнг тусгадаг ба энэ нь төлбөрийн тэнцэлтэй уялддаг.

1. Тооцох зарчим.

Төлбөрийн тэнцэлд барааны экспорт, импортыг аль алиныг нь ФОБ нөхцөлийн үнээр үнэлж тусгах ёстой бөгөөд харин барааны импорт нь гаалийн статистикт СИФ нөхцөлийн үнээр үнэлэгдсэн байдаг. Иймээс төлбөрийн тэнцлийн статистикийн олон улсын стандартын дагуу импортын дүнгээс даатгал, тээврийн өртгийг салган үйлчилгээний бүлэгт шилжүүлэн импортыг ФОБ

нөхцлөөр тооцож тусгана. Америк доллараар үнэлсэн бараа, үйлчилгээний гадаад худалдааны мэдээг тухайн сарын америк доллартай харьцах төгрөгийн албан ёсны дундаж ханшаар бодож төгрөгт шилжүүлнэ.

Төлбөрийн тэнцлийн 3 сарын гүйцэтгэлийн нийлбэрээр улирлын тооцоог гаргана.

2. Мэдээллийн эх үүсвэр:

Монгол банкнаас эмхтгэн гаргадаг төлбөрийн тэнцлийн сарын статистик мэдээлэл байна.

ДӨРӨВ. ДНБ-ИЙГ ЭЦСИЙН АШИГЛАЛТЫН АРГААР, УЛИРЛААР, ЗЭРЭГЦҮҮЛЭХ ҮНЭЭР ТООЦОХ АРГА ЗҮЙ

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ийг зэрэгцүүлэх үнээр үнэлэхдээ “Дотоодын нийт бүтээгдэхүүн болон үндэсний нийт орлого тооцох аргачлал”-д заасны дагуу эцсийн ашиглалтын бүрэлдэхүүн бүрийг холбогдох боломжит индексүүдэд хувааж тооцно гэсэн зарчмыг баримтална.

5.1 Эцсийн хэрэглээ

А. Өрхийн аж ахуйн хэрэглээ

Өрхийн аж ахуйн хэрэглээг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ зэрэгцүүлэх үнийн жилийн тооцооны зарчмаар өрхийн хэрэглээний индекс тооцогдсон бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрийг тухайн улирлын бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээний үнийн индекст хувааж тооцох ба бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний хувьд хэрэглээний үнийн холбогдох бүлгийн индекст хувааж тооцно.

Санхүү болон даатгалын үйлчилгээ, нийгмийн хамгааллын үйлчилгээний зардлыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ үйлдвэрлэлийн аргаар тооцсон санхүү болон даатгалын салбар, хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн салбарын улирлын нэмэгдэл өртгийн дефляторт хувааж тооцно.

Б. Төрийн удирдлагын байгууллагын хэрэглээ

Жилийн зэрэгцүүлэх үнийн тооцооны зарчмаар төрийн удирдлагын байгууллагын нэмэгдэл өртгийг цалингийн индекст хувааж, завсрын хэрэглээний зардлын нэр төрөл тус бүрийг тухайн улирлын тохирох боломжит индекс, дефляторт хувааж тооцно.

В. Төрийн бус байгууллагын хэрэглээ

Жилийн зэрэгцүүлэх үнийн тооцооны зарчмаар төрийн бус байгууллагын хэрэглээг үйлдвэрлэлийн аргаар тооцсон гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагааны дэд салбарын /94/ тухайн улирлын нийт үйлдвэрлэлийн дефляторт хувааж тооцно.

5.2 Нийт хөрөнгийн хуримтлал

А.Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал

Үндсэн хөрөнгийн нийт хуримтлалыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ жилийн зэрэгцүүлэх үнийн тооцооны зарчмаар бүрэлдэхүүн бүрийг тухайн улирлын тохирох индекс, дефляторт хувааж тооцно.

Б. Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт

Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлтийг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ бүрэлдэхүүн бүрийг тухайн улирлын тохирох дефляторт нь хуваана. Үүнд:

- Түүхий эд, материал, дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар тооцсон холбогдох салбар бүрийн нийт үйлдвэрлэлийн дефляторыг ашиглаж тооцно.
- Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн аргаар тооцсон бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт үйлдвэрлэлийн дефляторт хувааж тооцно.

В. Үнэт зүйлсийн хуримтлал

Үнэт зүйлсийн хуримтлалыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхдээ зэрэгцүүлэх үнийн жилийн тооцооны зарчмаар үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлийн бүлгийн /71/ тухайн улирлын экспортын үнийн индекст хувааж тооцно. Энэ нь Пааше индекс байна.

5.3 Бараа, үйлчилгээний цэвэр экспорт

А. Барааны экспорт, импорт

Зэрэгцүүлэх үнийн жилийн тооцоотой адил зарчмаар улирлын экспорт, импортын гүйцэтгэлийг тохирох боломжит бараагаар бүлэглэн, Пааше индексийг бүлэг тус бүрт нь тооцож, зэрэгцүүлэх үнэд шилжүүлнэ.

Б. Үйлчилгээний экспорт, импорт

Жилийн зэрэгцүүлэх үнийн тооцоотой адил зарчмаар тооцно.

Хавсралт 1.

Улирлын тооцоонд ашиглагдах мэдээлэл

1. Үйлдвэрлэлийн аргын тооцоонд:

дд	Салбар	Оны үнийн тооцоонд		Зэрэгцүүлэх үнийн тооцоонд	
		Тооцооны арга зүй	Үндсэн мэдээлэл	Тооцооны арга зүй	Үндсэн мэдээлэл
1	ХАА	НӨ = НҮ - ЗХ	Ургацын баланс, мал, тэжээвэр амьтдын тоо, ашиг шимийн бүтээгдэхүүн урьдчилсан байдлаар	Тоо хэмжээг дахин үнэлэх арга	Ургац, мал, малын ашиг шичмийн бүтээгдэхүүний үнийн мэдээ
2	Аж үйлдвэр Уул уурхайн туслах үйл ажиллагаа, хог хаягдал цуглуулах, цэвэрлэх үйл ажиллагаа	Нэмэгдэл өртгийн харьцааны арга	Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сарын мэдээ (АҮ-1) Хөрөнгө оруулалтын судалгаа, Орон сууц, нийтийн аж ахуйн орлого, зардлын улирлын мэдээ (ОСНАА-1)	Экстраполяцийн арга Дефляторын арга	Аж үйлдвэрийн салбарын индексийн тооцоо Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн индексийн тооцоо, ХҮИ
3	Барилга	Нэмэгдэл өртгийн харьцааны арга	Барилга угсралт, их засварын ажлын улирлын мэдээ (ИБ-1)	Дефляторын арга	Барилгын өртгийн индекс
4	Дотоод худалдаа	Экстраполяцийн арга	Худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын улирлын мэдээ (ХҮ-1а)	Дефляторын арга	ХҮИ
5	Тээвэр, агуулах	Экстраполяцийн арга	Авто, усан замын тээврийн тээвэр-лэлтийн улирлын мэдээ (Т-1), Агаарын тээврийн тээвэрлэлтийн сарын мэдээ (АТ-7), Төмөр замын тээвэрлэлтийн сарын мэдээ (АТ-9), Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний улирлын тайлан (ШХИҮ-1)	Экстраполяцийн арга	Тээвэр, шуудангийн үндсэн үзүүлэлтүүд
6	Зочид буудал, нийтийн хоолны үйлчилгээ	Экстраполяцийн арга	Зочид буудлын үйл ажиллагааны улирлын тайлан (ЗБ-1), Зоогийн газрын үйл ажиллагааны улирлын тайлан (ЗГ-1)	Дефляторын арга	ХҮИ
7	Мэдээлэл, холбоо	Экстраполяцийн арга	Шуудан, холбоо, интернэтийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйлчилгээний улирлын тайлан (ШХИҮ-1)	Экстраполяцийн арга	Холбооны үндсэн үзүүлэлтүүд

8	Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	Экстраполяцийн арга	Монголбанкны “Статистикийн сарын бюллетень”, Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг ААНБ-ын үйл ажиллагааны улирлын мэдээ БЗҮ-1а, Хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны улирлын мэдээ ХЗХ-1, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны улирлын мэдээ ББСБ-1, Даатгалын байгууллагын улирлын үйл ажиллагааны тайлан (Д-1)	Дефляторын арга	ХҮИ
9	Үл хөдлөх хөрөнгө	Зэрэгцүүлэх үнээрх НӨ-ийг шилжүүлэх арга	Салбарын нэмэгдэл өртгийн өмнөх оны мэдээлэл, ХҮИ	Экстраполяцийн арга	хүн амын урьдчилсан тоо
10	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа; Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Экстраполяцийн арга	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн орлого, зарлагын улирлын мэдээ (ЭШС-1), Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын сарын мэдээ, Мал эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн улирлын тайлан (МЭ-1), Аялал жуулчлалын салбарын орлого, зардлын улирлын судалгаа	Дефляторын арга	ХҮИ
11	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Дефляторын арга	Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, НДШ	Дефляторын арга	Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ-ий төрийн удирдлагын байгууллагын хэрэглээний дефляторт хуваана.
12	Боловсрол	Экстраполяцийн арга	Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, НДШ	Экстраполяцийн арга	Суралцагчдын тоо
13	Эрүүл мэнд	Экстраполяцийн арга	Төсөвт байгууллагын ажиллагчдын цалин, НДШ	Экстраполяцийн арга	Ажиллагчдын тоо
14	Урлаг, үзвэр, тоглоом наадам Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Экстраполяцийн арга	Улсын төсвийн мэдээ, Чөлөөт цаг, соёл, биеийн тамирын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн ААН-ийн орлого, зарлагын улирлын мэдээ (СБТ-1), Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын тайлан (ТББ-1), Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг ААН-	Дефляторын арга	ХҮИ

			ийн орлого, зардлын улирлын тайлан (НҮЗ-1), Сүм, хийдийн үйл ажиллагааны улирлын, жилийн тайлан (СХ-1).		
--	--	--	---	--	--